

## Санхүүгийн тусламжийн журам

### 1. ЖУРАМ:

- NorthShore - Edward-Elmhurst (NS-ЕЕН) эрүүл мэндийн системийн үндсэн зорилго нь NS-ЕЕН системээр үйлчлүүлдэг, тухайн харьяа газарт орших суух хувь хүмүүс, өрхүүдийн хэрэгцээг хангахуйц чанартай, үр дүнтэй эрүүл мэндийн асаргаа, тусламж үйлчилгээ, эрүүл мэндтэй холбоотой бусад үйлчилгээг үзүүлэх юм. Энэхүү журмыг хэрэгжүүлэх зорилгоор NS-ЕЕН эрүүл мэндийн систем нь дараах ашгийн бус эмнэлгүүдтэй хамтран ажилладаг: Evanston Hospital, Glenbrook Hospital, Highland Park Hospital, and Skokie Hospital (хамтад нь NorthShore” гэх), Swedish Hospital, Northwest Community Hospital (NCH), Edward Hospital, Elmhurst Hospital, Linden Oaks Hospital (хамтад нь “ЕЕН” гэх). Тодорхой эмнэлгүүдэд хамаарах журмууд зөрүүтэй байх тохиолдолд тус тусад нь тодорхойлно.
- Энэрэн нигүүлсэл ба хүлээсэн үүргийнхээ үнэт зүйлсийн дагуу NS-ЕЕН систем нь мөнгө, санхүүгийн гачигдалтай өвчтөнүүдэд санхүүгийн тусламж үзүүлэх журмыг хэрэгжүүлдэг. Мөн түүнчлэн энэхүү Санхүүгийн тусламжийн журмын (СТЖ) зорилго нь NS-ЕЕН системээс үзүүлж буй яаралтай эсвэл эмнэлгийн шаардлагатай тусламж үйлчилгээтэй холбогдуулан өвчтөнүүдэд санхүүгийн тусламж үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх зорилготой.
- Энэхүү журам нь санхүүгийн байдал нь үйлчилгээний төлбөрөө бүрэн төлөх боломжгүй хүмүүст NS-ЕЕН системийн зүгээс тусламж үзүүлэх тодорхой шалгуур үзүүлэлт, өргөдөл гаргах үйл явцыг тодорхойлно. Тодорхой хувь хүмүүс үйлчилгээнүүдийг үнэ төлбөргүйгээр авах үндэслэлтэй гэдгийг анхаарна уу (4.E хэсгийг үзнэ үү).
- Энэхүү журам нь NS-ЕЕН-ийн эмнэлгээс үзүүлж буй яаралтай болон эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд хамааралтай. Энэхүү журмыг эмнэлгээс гадуурх эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд заавал дагаж мөрдөх үүрэг хүлээхгүй. СТЖ-ын **Хавсралт 1**-ээс үзүүлдэг үйлчилгээ нь энэхүү журмын үйлчлэх хүрээнд тус журмын нэг хэсэг байдлаар хамрагддаг, яаралтай болон бусад эмнэлгийн шаардлагатай тусламж үйлчилгээгээ эмнэлгийн байгууламжид үзүүлдэг тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын мэдээлэл болон үйлчилгээ нь энэхүү журамд хамрагддаггүй үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалтыг харах боломжтой. Хэрэв та энэхүү журмын дагуу санхүүгийн тусламж авах шаардлагыг хангаж байгаа нь тогтоогдвол үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээнд хамрагдах боломжтой гэдгийг анхаарна уу. **Хавсралт 1**-ийн хэвлэмэл хувийг онлайн-аар эсвэл өргөдөл гарган энэхүү журмын 4.I хэсэгт жагсаасан харьяа орон нутгуудаас авах боломжтой.
- NS-ЕЕН нь өвчтөнд даатгалын хөтөлбөрийн хамрах хүрээний хязгаарлалтуудын талаар ойлголт, мэдлэг олгохын тулд хүчин чармайлт гаргаж, холбооны Эмнэлгийн яаралтай тусламж эмчилгээ ба хөдөлмөрийн хуулиар (EMTALA/ЭЯТЭХХ) хүлээсэн үүргээ биелүүлсний дараа өөр үйлчилгээ үзүүлэгчийн даатгалын хөтөлбөрт хамрагддаг боловч NS-ЕЕН системд хамрагддаггүй үйлчилгээнүүдийг энэ журмаас хасаж болно.
- Энэхүү журам нь NS-ЕЕН системийн санхүүгийн тусламжийн хөнгөлөлтийн дүнг тооцохдоо ашигладаг шалгуур үзүүлэлт, мөн хэрэв байдаг бол NS-ЕЕН-ийн зүгээс авах тус байгууллагын үйлчилдэг газар нутгийн хэмжээнд энэхүү СТЖ-ыг өргөн хүрээнд сурталчлах арга хэмжээнүүд, санхүүгийн тусламж авах шаардлага хангасан эсэхийг тодорхойлдог. Төлбөр төлөөгүй тохиолдолд NS-ЕЕН системийн зүгээс авч болох арга хэмжээнүүдийг **Нэхэмжлэх ба төлбөр барагдуулалтын журамд** тусад нь дурдсан болно. Тус журмын талаарх мэдээллийг онлайн-аар эсвэл өргөдөл гарган энэхүү журмын 4.I хэсэгт жагсаасан харьяа орон нутгуудаас авах боломжтой.
- Санхүүгийн тусламж авах эрхтэй болохын тулд та санхүүгийн тусламж авах өргөдлийг (албан ёсоор ийм үйлчилгээ авах эрхгүй байгаа өвчтөнүүдийн хувьд) бөглөж, шаардагдах нэмэлт бичиг баримтын хамт ирүүлэх ёстой. Санхүүгийн тусламж авах өргөдлийг санхүүгийн тусламж авахыг хүсэж буй үйлчилгээнүүдтэй холбогдуулан илгээсэн хамгийн эхний тооцооны мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 240 хоногийн дотор ирүүлнэ. Энэхүү журамд доор дурдсанчлан дээрх нөхцөлд үл хамаарах тайлбарыг өгч болно. Энэ журамд агуулагдсан ямар ч зүйл, заалт өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр буй эсвэл ирээдүйд хүчин төгөлдөр үйлчлэх холбооны, мужийн, орон нутгийн хууль тогтоомжоос давж үйлчлэхгүй.

- NS-ЕЕН нь NS-ЕЕН-ийн Үйл ажиллагааны нэгдсэн оффис, Шведийн Эмнэлгийн Санхүүгийн Үйлчилгээний Төв, NCH Санхүүгийн зөвлөх албатай хамтран ХЯТ-гийн шалгуурыг тогтооход үндэслэлтэй хүчин чармайлт гаргасан эсэхийг тодорхойлох эрхтэй. Энэхүү журам нь энэрэн нигүүлсэл ба үүрэг хариуцлагынхаа үнэт зүйлсийн дагуу NS-ЕЕН-ийн хүн амд тусламж үзүүлэх зорилготой. Тус Санхүүгийн тусламжийн журам нь ямар нэгэн өвчтөнд санхүүгийн тусламж үзүүлэх санал биш бөгөөд ямар ч гэрээний эрх, үүргийн харилцааг үүсгэхгүй болно. NS-ЕЕН-ийн зүгээс энэхүү СТЖ-ыг өөрийн үзэмжээр шинэчилж болно.
- Энд дурдсан журам, үйл ажиллагаануудыг Иллиной муж улсын дүрэм журам ба Дотоод Орлогын Кодын 501(г) хэсэг болон холбогдох удирдамжид нийцүүлэн боловсруулсан.

## 2. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү журам нь NS-ЕЕН-ийн эмнэлгээс үзүүлж буй яаралтай болон эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд хамааралтай. Энэхүү журмыг эмнэлгээс гадуурх эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд заавал дагаж мөрдөх үүрэг хүлээхгүй. СТЖ-ын **Хавсралт 1**-ээс үзүүлдэг үйлчилгээ нь энэхүү журмын үйлчлэх хүрээнд тус журмын нэг хэсэг байдлаар хамрагддаг, яаралтай болон бусад эмнэлгийн шаардлагатай тусламж үйлчилгээгээ эмнэлгийн байгууламжид үзүүлдэг тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын мэдээлэл болон үйлчилгээ нь энэхүү журамд хамрагддаггүй үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалтыг харах боломжтой. Хэрэв та энэхүү журмын дагуу санхүүгийн тусламж авах шаардлагыг хангаж байгаа нь тогтоогдвол үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээнд боломжтой гэдгийг анхаарна уу. **Хавсралт 1**-ийн хэвлэмэл хувийг онлайн-аар эсвэл өргөдөл гарган энэхүү журмын 4.I хэсэгт жагсаасан харьяа орон нутгуудаас авах боломжтой.

## 3. ТОДОРХОЙЛОЛТ:

Гэр бүл - Өвчтөн, өвчтөний гэр бүлийн хүн/хамтран амьдрагч, өвчтөний эцэг эх, эсвэл асран хамгаалагч (бага насны хүүхдийн хувьд) болон өвчтөний эсвэл өвчтөний эцэг эхийн орлогын татварын буцаалтын тайланд нэхэмжлэгчээр бичигдсэн болон өвчтөний эсвэл өвчтөний эцэг эх, асран хамгаалагчийн ам бүлд багтан амьдардаг аливаа тэтгүүлэгч хүнийг ойлгоно.

Даатгалгүй өвчтөн - Эрүүл мэндийн даатгалын журамд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хамрагдаагүй, улсын болон хувийн эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн тэтгэмж, бусад эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрийн (хувийн даатгал, Medicare, эсвэл Medicaid эсвэл гэмт хэргийн хохирогчдод тусламж үзүүлэх хөтөлбөр зэргийг оролцуулан тэдгээрээр үл хязгаарлагдах) дагуу тэтгэмж тусламж авдаггүй, NS-ЕЕН системээс үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрөө төлөхөд тухайн өвчтөний гэмтэл нь NS-ЕЕН-ийн мөрддөг бичиг баримтууд болон өвчтөний өөрийнх нь өгсөн эсвэл бусад эх үүсвэрээс олж авсан мэдээлэлд тодорхойлогдсоноор ажилчдын нөхөн олговор, автомашины даатгал, эсвэл бусад гуравдагч этгээдийн даатгалын хүрээнд даатгал, тусламжид хамрагдахааргүй өвчтөнийг ойлгоно.

Нэхэмжилсэн ерөнхий дүнд (НЕД) - Санхүүгийн тусламж авах шаардлага хангасан өвчтөнүүдээс яаралтай тусламжийн болон эмнэлгийн зайлшгүй тусламжийн үйлчилгээний төлбөрийг даатгалтай өвчтөнүүдийн нэхэмжилсэн ерөнхий дүнгээс (НЕД) хэтэрсэн дүнгээр нэхэмжлэхгүй.

- 1) NS-ЕЕН-ийн НЕД-ийн хувь хэмжээг 12 сарын хугацаанд эдгээр нэхэмжлэлд ногдуулсан нийт дүнд хуваагдсан “Медикэйр” (Medicare) үйлчилгээний хураамж болон хувийн эрүүл мэндийн даатгуулагчийн нэхэмжлэлийн нийт дүнд болох “дахин хянах” аргыг ашиглан тооцно. Өвчтөнүүдээс НЕД-ээс хэтэрсэн хэмжээгээр төлбөр нэхэмжлэхгүйн тулд НЕД-ийн хувийн хязгаарыг бодолцон санхүүгийн тусламж авах шаардлагыг хангасан өвчтөнүүдэд олгох хөнгөлөлтийг дахин хянаж үзнэ.
- 2) НЕД-ийн хувь хэмжээг СТЖ-ын **Хавсралт 2**-оос үзнэ үү.
- 3) НЕД-ийн хувь хэмжээг жил бүр шинэчлэн тооцдог бөгөөд он гарснаас хойш 120 дахь өдрийн дараа мөрдөж эхэлнэ.

Өргөдөл - Өвчтөний бөглөх санхүүгийн тусламж авах тухай өргөдлийг ойлгоно.

Өргөдөл гаргах хугацаа - Өргөдөл гаргах хугацааны турш NS-ЕЕН санхүүгийн тусламж авах өргөдлийг хүлээн авч, боловсруулна. Өргөдөл гаргах хугацаа хувь хүнд асаргаа үйлчилгээ үзүүлсэн өдрөөс эхэлж үзүүлсэн асаргаа үйлчилгээний эхний нэхэмжлэх ирсэн өдрөөс хойш 240 дэх хоног дээр дуусна.

Өрхийн орлого - Татвар төлөхөөс өмнөх бүх эх үүсвэрээс олсон өрхийн жилийн орлого ба мөнгөн тэтгэмжийн дүнд, АНУ-ын Дотоод орлогын албанд тайлагнах хүүхдийн тэтгэмжийн төлбөрийг ойлгоно. Өрхийн орлогод ажилгүйдлийн нөхөн олговор, ажилчдын цалин хөлс, Нийгмийн даатгал, Нэмэлт халамжийн орлого, олон нийтийн

тусламж, ахмад дайчдын тэтгэмж, тэжээгчээ алдсаны тэтгэмж, тэтгэвэр буюу тэтгэврийн орлого, хүү, ногдол ашиг, тэтгэлэг, хүүхдийн тэтгэлэг болон бусад эх үүсвэр багтдаг боловч эдгээрээр хязгаарлагдахгүй.

**Санхүүгийн тусламж** - Санхүүгийн тусламж гэдэг нь NS-ЕЕН системийн СТЖ-д тодорхойлсноор санхүүгийн болон бусад төрлийн тусламж авах эрхийн шалгуур үзүүлэлтийг хангасан өвчтөнүүд эмнэлгийн байгууламж дотор NS-ЕЕН системийн зүгээс үзүүлсэн чухал шаардлагатай болон яаралтай эрүүл мэнд асаргааны тусламж үйлчилгээнийхээ төлбөрийг төлөхөд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг олж авахад нь туслах зорилгоор NS-ЕЕН-ээс санал болгодог тусламж юм. Эрхийн шалгуур үзүүлэлтийг хангасан өвчтөнүүдэд даатгалд хамрагдаагүй, бага орлоготой өвчтөнүүд, хэсэгчилсэн даатгалд хамрагдсан боловч эмнэлгийн төлбөрийн үлдсэн хэсгийг эсвэл бүхэлд нь төлж чадахгүй байгаа өвчтөнүүдийг хамруулан ойлгоно.

**Сонгох үйлчилгээ** - гэж шуурхай арга хэмжээ шаардахгүй нөхцөл байдлыг зохицуулах үйлчилгээнүүдийг хэлнэ. Сонгох үйлчилгээ гэдэгт яаралтай биш боловч өвчтөнд тустай, хэрэгтэй үйл ажиллагаанууд, мөн зөвхөн гадаад төрхийг сайжруулах зорилгоор хийгддэг гоо сайхны болон эрүү нүүрний мэс засал эсвэл эрүүл мэндийн даатгалын төлөвлөгөөнд ерөнхийдөө багтдаггүй бусад сонгох үйлчилгээ багтана. Эмнэлгийн шаардлагатай үйлчилгээнд багтахгүй сонгох үйлчилгээнүүдэд санхүүгийн тусламж олгохгүй.

**Төлбөр барагдуулах тусгай арга хэмжээ (ТБТАХ)** - Эдгээр нь хууль эрх зүйн эсвэл шүүхийн үйл явц шаардсан болон өр төлбөрийг өөр нэг этгээдэд зарах эсвэл зээл олгох байгууллагууд эсвэл товчоодод сөрөг мэдээлэл тайлагнах гэх мэт бусад үйл ажиллагааг хамарсан төлбөр барагдуулах үйл ажиллагаанууд юм. NS-ЕЕН-ийн зүгээс ийм ТБТАХ-д оролцдоггүй бөгөөд төлбөр барагдуулах ажилтнуудаа ч ТБТАХ-ийг авч хэрэгжүүлэхийг зөвшөөрдөггүй. NS-ЕЕН системийн төлбөр барагдуулалтын журмын талаарх нэмэлт мэдээллийг NS-ЕЕН-ийн **Нэхэмжлэх ба төлбөр барагдуулах журмын** хэсгээс үзэх боломжтой. Энэхүү журмын хэвлэмэл хувийг онлайнгаар эсвэл өргөдөл гарган энэхүү журмын 4.1 хэсэгт жагсаасан харьяа орон нутгуудаас авах боломжтой.

**Үндэслэлтэй эрх бүхий байдал** - Санхүүгийн тусламж хүссэн өргөдлийг бөглөлгүйгээр даатгалгүй өвчтөний санхүүгийн хэрэгцээ шаардлагыг харуулсан хэмээн үзсэн тодорхой шалгуур үзүүлэлтийг үндэслэн санхүүгийн тусламж авах эрх, шаардлага хангасан байдлыг тодорхойлсон тодорхойлолт ойлгоно.

**Хангалттай хүчин чармайлт** - NS-ЕЕН нь СТЖ-ын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуйг өвчтөнд санал болгож, NS-ЕЕН СТЖ-ийн талаар тодорхой мэдээлэл хүргэхийн тулд хангалттай хүчин чармайлт гаргана. Мөн түүнчлэн өвчтөнүүдэд NS-ЕЕН СТЖ-ын талаар мэдээлэл өгөхийн тулд NS-ЕЕН дараах алхамуудыг хийж гүйцэтгэнэ.

- 1) **Өргөдлийг дутуу бөглөх** - Хэрэв өвчтөн/өвчтөний гэр бүлийн гишүүн санхүүгийн тусламж хүссэн өргөдлийг бүрэн бус, дутуу бөглөж өгвөл NS-ЕЕН шаардагдах нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг тодорхойлсон мэдэгдлийг бичгээр гаргаж өгнө.
- 2) **Өргөдлийг бүрэн бөглөх** - Хэрэв өвчтөн/өвчтөний гэр бүлийн гишүүн санхүүгийн тусламж хүссэн өргөдлийг бүрэн бөглөж өгвөл NS-ЕЕН тухайн өвчтөн санхүүгийн тусламж авах эрхтэй эсэхийг тодорхойлох мэдэгдлийг цаг тухайд нь бичгээр гарган өгч, тухайн өвчтөнд энэ шийдвэр (мөн боломжтой бол, тухайн өвчтөний авч болох тусламжийн тухай) болон шийдвэрийг гаргасан үндэслэлээ бичгээр мэдэгдэнэ. Уг мэдэгдэлд мөн санхүүгийн тусламжийн хувиар тооцсон дүн (зөвшөөрөгдсөн өргөдлийн хувьд) эсвэл татгалзсан шалтгаан, өвчтөн ба гэр бүлээс нь төлөх төлбөрийн дүнг оруулна. Бөглөсөн өргөдлийг үнэлэх явцад өвчтөн болон түүний гэр бүл өвчтөнд илгээх мэдэгдлийг үргэлжлүүлэн хүлээж авна.
- 3) **Өвчтөнд мэдэгдэл ирүүлэх** - NS-ЕЕН нь өвчтөнд тухайн өвчтөний тооцоо ба төлөх ёстой дүнг дурдсан хэд хэдэн мэдэгдэл илгээнэ. Өвчтөнд ирүүлэх мэдэгдэлд тухайн өвчтөн өөрийн хамрагдсан аливаа эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээллийг NS-ЕЕН-д мэдэгдэх үүрэгтэйг сануулсан бичиг, NS-ЕЕН СТЖ-ын талаарх мэдэгдэл, санхүүгийн тусламж хүсэх утасны дугаар, санхүүгийн тусламж хүсэхэд шаардагдах бичиг баримтуудыг авч болох вебсайтын хаягууд багтана.
- 4) **NS-ЕЕН-ийн вебсайт** - NS-ЕЕН нь вебсайтаа санхүүгийн тусламж авах боломжтой талаарх мэдээллийг санхүүгийн тусламж хүсэх өргөдөл гаргах үйл явцын талаарх тайлбарын хамт харагдахуйц газар байрлуулна. NS-ЕЕН нь СТЖ-ыг СТЖ-д хамрагдсан болон хамрагдаагүй үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалт, энгийн хэл найруулгаар бичигдсэн хураангуй, санхүүгийн тусламж авах өргөдөл, нэхэмжлэх, төлбөр барагдуулалтын журмыг онлайнгаар эсвэл 4.1 хэсэгт жагсаасан харьяа орон нутгуудаас авах боломжтой.

**Холбооны ядуурлын түвшин (ХЯТ)** - Хувь хүнийг ядуурлын босгон дээр байна хэмээн тооцсон орлогын түвшин. Энэхүү орлогын түвшин нь гэр бүлийн нэгжийн тооноос хамаарч харилцан адилгүй байдаг. Ядуурлын түвшинг АНУ-ын Эрүүл мэнд, Хүний үйлчилгээний газраас жил бүр шинэчилж, Холбооны Бүртгэлд оруулж нийтлүүлдэг. Энэхүү журмын үүднээс эдгээр нийтлэгдсэн удирдамжид заасан ядуурлын түвшин нийт орлогыг илэрхийлнэ. Энэхүү журамд дурдсан ХЯТ-гийн зорилтыг жил бүр шинэчилнэ. СТЖ-ын **Хавсралт 3**-аас ХЯТ-г үзн үү.

Эмнэлгийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээ - Орон нутгийн эрүүл мэндийн стандарт шаардлагыг хангасан, оношлох, эмчлэх, асрахад чиглэсэн, Medicare болон Медикад (Medicaid) хөтөлбөрүүдэд эмнэлгийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээ хэмээн тогтоосон, өвчтөн эсвэл эмчийн тав тухыг хангахад голлон чиглээгүй үйлчилгээ, хангамжуудыг ойлгоно. Эмнэлгийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээнд гоо сайхны мэс засал, нийгмийн, боловсролын болон мэргэжлийн үйлчилгээ гэх мэт эмнэлгийн бус үйлчилгээнүүдийг хамруулахгүй.

Энгийн хэл найруулгаар бичсэн хураангуй - NS-EEN системийн СТЖ-ын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуйд: 1) тавигдах шаардлагууд болон санал болгосон тусламжийн товч тодорхойлолт; 2) санхүүгийн тусламж авах өргөдлийг авч болох вебсайт болон газруудын байршлын жагсаалт; 3) СТЖ-ын хэвлэмэл хувийг хэрхэн үнэ төлбөргүй авах зааварчилгаа; 4) өргөдөл гаргах явцад шаардлагатай тусламж авахад шаардагдах холбоо барих мэдээлэл; 5) СТЖ болон холбогдох бичиг баримтуудыг ямар ямар хэлээр орчуулсан талаарх мэдээлэл; 6) санхүүгийн тусламж авах эрхтэй хэмжээн тодорхойлогдсон өвчтөнд яаралтай тусламжийн эсвэл эмнэлгийн шаардлагатай үйлчилгээнд НЕД-гээс хэтрэхгүй дүнгээр төлбөр тооцохыг баталгаажуулсан мэдэгдэл багтана.

Яаралтай үйлчилгээ - Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэхгүй байх нь хувь хүний эрүүл мэндийн байдлыг ноцтой аюулд хүргэх (жирэмсэн эмэгтэй, эмэгтэй хүн эсвэл хэвлийд байгаа хүүхдийн хувьд), эсвэл бие махбодын үйл ажиллагаанд ноцтой хохирол учруулах, эсвэл бие махбодын аль нэг эрхтний хэвийн үйл ажиллагааг ноцтой сааталд оруулж болзошгүй, хүндрэлийн хурц шинж тэмдэг (маш ноцтой өвдөлт, сэтгэцийн эмгэг/мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх шинж тэмдэг орно) бүхий өвчтөнд үзүүлэх үйлчилгээг ойлгоно.

Яаралтай үйлчилгээнүүд - Амь насанд аюултай биш боловч эмчилгээг удаан хугацаагаар хойшлуулах нь өвчтөний эрүүл мэнд, биеийн ерөнхий байдалд аюул учруулж болзошгүй, эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай (ихэвчлэн 48 цагийн дотор) гэнэтийн өвчин эсвэл осол гэмтлийг эмчлэх үйлчилгээнүүдийг хэлнэ.

#### 4. ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- A. *Өвчтөнтэй харилцах*: Өвчтөнүүддээ болон тэдний гэр бүлийнхэн, нийгэмд илүү өргөн хүрээнд санхүүгийн тусламжийн талаар мэдээллийг хүргэх үүднээс эмнэлгүүдэд ирсэн өвчтөнүүд, иргэдэд санхүүгийн тусламж авах боломж, түүний хүртээмжтэй байдлын талаар мэдээлж, эмнэлгээр үйлчлүүлдэг нийгмийн бүлгийн гишүүдэд энэхүү журмыг өргөн хүрээнд сурталчлахын тулд NS-EEN-ийн зүгээс хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Эдгээр арга хэмжээнд:
- i. *Санхүүгийн зөвлөх алба*: NS-EEN-ийн өвчтөнүүд эмнэлгийн тооцооныхоо тодорхой хэсгийг төлөхөд хүндрэл учирч болзошгүй гэж үзвэл эмнэлгийн санхүүгийн зөвлөхөөс мэдээлэл авах боломжтой. Даатгалгүй, бага даатгалтай, эсвэл бидний үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбогдуулан санхүүгийн бэрхшээлтэй тулгараад байгаа өвчтөнүүддээ тусламж үзүүлэхийн тулд манай санхүүгийн зөвлөхүүд боломжит бүх хүчин чармайлтаа гарган ажилладаг. Зөвлөхүүд өвчтөнүүдийг засгийн газраас санхүүждэг төрөл бүрийн хөтөлбөрүүдийн шаардлагыг хангасан эсэхийг хянах, ажилчдын цалин, өр төлбөрийн нэхэмжлэх дээр нь шаардлагатай тусламж үзүүлэх, төлбөр төлөх уртасгасан хугацаат төлөвлөгөө гаргах эсвэл санхүүгийн тусламж авах өргөдөл гаргахад нь өвчтөнд туслах зэргээр ажиллаж болно.
  - ii. *Энгийн хэл найруулгаар бичсэн хураангуй*: NS-EEN-ийн СТЖ-ын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуйг хэвлэмэл хэлбэрээр бүх өвчтөнд санал болгодог. NS-EEN нь санхүүгийн тусламжийн бичиг баримтуудын хэвлэмэл хувилбарыг онлайнээр эсвэл өргөдөл гарган энэхүү журмын 4.I хэсэгт жагсаасан харьяа орон нутгуудаас авах боломжтой.
  - iii. *Бэлэн байгаа орчуулагдсан хуулбарууд*: NS-EEN-ийн зүгээс өөрийн СТЖ, энгийн хэл найруулгаар бичсэн хураангуй, санхүүгийн тусламж авах өргөдөл болон Нэхэмжлэх ба төлбөр барагдуулалтын журмыг Англи болон NS-EEN эмнэлгүүдээр үйлчлүүлэх магадлалтай хүн амын 5 хувь буюу 1,000-аас бага хувь хүний ярьдаг бусад хэлээр гаргадаг. NS-EEN нь эдгээр бичиг баримтын хэвлэмэл хувилбарыг онлайнээр эсвэл өргөдөл гарган энэхүү журмын 4.I хэсэгт жагсаасан харьяа орон нутгуудаас авах боломжтой.
  - iv. *“Бид тусалж чадна” самбар*: Санхүүгийн тусламжийн бүхий л самбарыг NS-EEN-ийн яаралтай тусламжийн тасаг, өвчтөний бүртгэлийн хэсгүүд зэргээр үл хязгаарлагдах олон хүнд шууд харагдахуйц байршлуудад маш илэрхий, тодорхой байрлуулна. Эдгээр самбар нь санхүүгийн тусламж авах боломжтойг илэрхийлэхээс гадна нэмэлт мэдээлэл авахын тулд санхүүгийн зөвлөхтэй холбогдох утасны дугаарыг багтаасан байна.
  - v. *Товхимол*: Товхимлуудыг NS-EEN-ийн өвчтөн хүлээн авах, бүртгэлийн болон яаралтай тусламжийн тасгууд, кассууд дээр байрлуулах бөгөөд тэдгээрт өвчтөн Medicare, Medicaid, Оол Кидс (All Kids), Фамили Кейр (Family) зэрэг NS-EEN-ийн санхүүгийн тусламжийн хөтөлбөрт хамрагдахын тулд хэрхэн өргөдөл

гаргах талаар удирдамжийг тусгана. Мөн санхүүгийн тусламжийн талаар мэдээлэл авах, өргөдөл гаргахын тулд тусламж авахад шаардагдах холбоо барих мэдээлэл, утасны дугаарыг оруулна.

- vi. *Вебсайт*: NS-ЕЕН нь вебсайтдаа санхүүгийн тусламж авах боломжтой талаарх мэдээллийг санхүүгийн тусламж хүсэх үйл явцын талаарх тайлбарын хамт харагдахуйц газар байрлуулна. NS-ЕЕН нь өөрийн СТЖ-ыг СТЖ-д хамрагдсан болон хамрагдаагүй үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалт, энгийн хэл найруулгаар бичигдсэн хураангуй, санхүүгийн тусламжийн өргөдөл, нэхэмжлэх ба төлбөр барагдуулалтын журмын хамт нийтэлнэ. NS-ЕЕН нь эдгээр бичиг баримтыг өргөдөл гарган энэхүү журмын 4.I хэсэгт жагсаасан харьяа орон нутгуудаас авах боломжтой.
  - vii. *Өвчтөний тооцоо ба өвчтөнд илгээх мэдэгдэл*: Өвчтөнд ирүүлэх мэдэгдэлд тухайн өвчтөн өөрийн хамрагдсан аливаа эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээллийг NS-ЕЕН-д мэдэгдэх үүрэгтэйг сануулсан бичиг, NS-ЕЕН СТЖ-ын талаарх мэдэгдэл, санхүүгийн тусламж хүсэх утасны дугаар, санхүүгийн тусламж хүсэхэд шаардагдах бичиг баримтуудыг авч болох вебсайтын хаягууд багтана.
- В. Шаардлага хангасан байдлыг тодорхойлох нь:** Хувь хүний санхүүгийн хэрэгцээг үнэлэх үйл ажиллагааны дагуу санхүүгийн хэрэгцээг нь тодорхойлдог. Эдгээр үйл ажиллагааг доор тайлбарлав. Үүнд:
- i. Доорх 4.E хэсэгт дурдсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үндэслэлтэй шаардлага хангасан байдлыг тодорхойлох үйл явцыг гүйцэтгэдэг. Хэрэв өвчтөн үндэслэлтэйгээр санхүүгийн тусламжийг авах эрхтэй бол санхүүгийн тусламж хүсэх өргөдөл гаргах шаардлагагүй. Өвчтөн эсвэл батлан даагч хяналтын үйл явцад хамтран ажиллаж, үндэслэл бүхий шаардлага хангасан байдлын тодорхойлолтыг гаргахтай холбоотой хувийн болон санхүүгийн мэдээлэл, бичиг баримтуудаа өгнө;
  - ii. Өвчтөн эсвэл батлан даагч хяналтын үйл явцад хамтран ажиллаж, үндэслэл бүхий шаардлага хангасан байдлын тодорхойлолтыг гаргахтай холбоотой хувийн болон санхүүгийн мэдээлэл, бичиг баримтуудаа өгөх санхүүгийн тусламж хүсэх өргөдлийн үйл явц;
  - iii. Төлбөрийн боломжит өөр эх үүсвэрийг болон төрийн ба хувийн байгууллагын төлбөрийн хөтөлбөрүүдийн хамрах хүрээг судлах ба тэдгээр хөтөлбөрт өргөдөл гаргахад нь өвчтөнүүдэд туслах NS-ЕЕН-ийн хүчин чармайлт юм. Дараах зүйлсийг ашиглан хамрах хүрээг судлах боломжтой:
    - a) Ажилчны цалин хөлс эсвэл хувь хүний гэмтлийн нэхэмжлэхийн талаарх боломжит вебсайтууд болон холбоо барих мэдээлэл
    - b) Цагдан хорих байранд байгаа өвчтөнүүдэд зориулсан холбоо барих мэдээлэл
    - c) Нээлттэй бүртгэлийн үеэр эрүүл мэндийн хамрах хүрээний солилцооны хөтөлбөрт бүртгүүлсэн өвчтөнүүдэд зориулсан “Get Covered Illinois” вебсайт
    - d) Эрүүл мэндийн даатгалын хамрах хүрээ, олон нийтийн тусламжийн хамрах хүрээ, Иргэдэд Үйлчлэх Департамент (DHS/ИҮД) нийгмийн үйлчилгээнүүд, Иллиной муж улсын Эрүүл Эмэгтэйчүүдийн Хөтөлбөр (Healthy Women’s program), зөвхөн Бөөрний эмчилгээ үйлчилгээ, Хэрэгцээт өрхүүдэд зориулсан түр тусламжийн хөтөлбөр (Temporary Assistance for Needy Families (TANF)) зэрэг хөтөлбөрүүдийн шаардлага хангаж буй байдлын талаар хайлт хийх eCareNext хэрэгсэл (Passport OneSource порталын нэг хэсэг)
    - e) Олон нийтийн тусламжийн хөтөлбөрийн хамрах хүрээний талаар хайлт хийхийн тулд тус мужийн Олон нийтийн тусламжийн мэдээллийн систем (PACIS/ОНТМС)/Эрхийн нэгдсэн системийн (IES/ЭНС) мэдээллийн сан
    - f) Иллиной муж улсын Цахим тэтгэмж шилжүүлэх (EBT/ЦТШ) картын вебсайтаар Нэмэлт шим тэжээлийн тусламжийн хөтөлбөрийн (SNAP/НШТТХ) хайлтын хэрэгсэл
    - g) Олон нийтийн тусламжийн хамрах хүрээнд хайлт хийх Экспериан (Experian) буюу PARO эрхийн хэрэгсэл
    - h) Гуравдагч этгээдийн бусад эх үүсвэр
  - iv. Өвчтөн эсвэл батлан даагчийн төлөх чадвартай талаар мэдээлэл өгөх олон нийтэд ил тод болсон мэдээллийн эх үүсвэрийг ашиглах (зээлийн оноо гэх мэт) (4.G. хэсгийг үзнэ үү);
  - v. NS-ЕЕН-ээр үйлчлүүлсэн өвчтөний өмнөх үйлчилгээнүүдийн төлөгдөөгүй төлбөр тооцоо, өвчтөний төлбөрийн болон найдваргүй өр төлбөрийн түүхийг хянан үзэх;
  - vi. NS-ЕЕН системээс үзүүлэх санхүүгийн тусламжийн түвшнийг өрхийн орлого, ам бүлийн тоо, ХЯТ зэрэгт үндэслэн тогтоодог. Даатгалтай болон даатгалгүй өвчтөний аль аль нь санхүүгийн тусламж хүсэж болно.
  - vii. Өвчтөний санхүүгийн тусламж авах эрх бүхий байдлыг доорх хүснэгтэд үндэслэн тодорхойлох бөгөөд энэ нь санхүүгийн нөхцөл байдал болон гуравдагч этгээдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний боломж

зэргийг хөнгөвчилж, өвчтөний санхүүгийн байдалд үндэслэн харилцан адилгүй байна. Шаардлага хангах тухай удирдамжийг жил бүр шинэчилнэ. Доор дурдсан удирдамжид заасан хэмжээг давсан орлого бүхий өрхүүдийг төлбөрийн төлөвлөгөөнд хамруулахаар хянаж болно.

- C. *Даатгалгүй өвчтөний санхүүгийн тусламж авах эрх бүхий байдал:* Холбооны ядуурлын түвшинд (FPL/ХЯТ) тулгуурлан, санхүүгийн тусламж авах шаардлага хангасан даатгалгүй өвчтөнүүдэд санал болгох хөнгөлөлтийг тодорхойлоход дараах хүснэгтийг ашиглана. Өвчтөнүүдээс НЕД-ээс хэтэрсэн хэмжээгээр төлбөр нэхэмжлэхгүйн тулд НЕД-ийн хувийн хязгаарыг бодолцон санхүүгийн тусламж авах шаардлагыг хангасан өвчтөнүүдэд олгох хөнгөлөлтийг дахин хянаж үзнэ.

ХЯТ-ний шатлал	0% – 200% ХЯТ	201% - 600% ХЯТ
Өвчтөний тооцоолсон төлбөр	\$0 төлбөр/100% хасах	НЕД-ийн хувь хэмжээ (Хавсралт 2-ийг үзнэ үү)
Өвчтөний жил тутмын тооцоолсон төлбөрийн хамгийн өндөр дүн	\$0 төлбөр/100% хасах	Өрхийн жилийн орлогын 20%

- i. СТЖ-ын **Хавсралт 3**-аас ХЯТ-ний мэдээллийг үзэж болох ба эмнэлэг тус бүрийн НЕД-гийн хувь хэмжээг **Хавсралт 2**-оос үзнэ үү.
  - ii. NS-ЕЕН-ийн эмнэлгийн үйлчилгээний тооцоолсон төлбөрийг тодорхойлохдоо даатгалгүй өвчтөний төлбөр тооцоон дээрх эмнэлгийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээний төлбөрийг ХЯТ нь хоёроос зургаагийн хооронд байдаг өрхийн орлоготой өвчтөнд тооцсон эмнэлгийн өртөг үнийн харьцаагаар тодорхойлно. Шинэчилсэн хувь хэмжээг жил бүр тооцоолох ба оны эхнээс хойш 120 дахь өдрөөс мөрдөж эхэлнэ. ХЯТ-ний шатлалаар тооцсон NS-ЕЕН-ийн хөнгөлөлтийн хувь хэмжээг **Хавсралт 4**-өөс үзнэүү . ХЯТ-ний шатлалаар тооцсон Шведийн эмнэлгийн хөнгөлөлтийн хувь хэмжээг **Хавсралт 5**-аас үзнэ .үү ХЯТ-ний шатлалаар тооцсон NCH-ийн хөнгөлөлтийн хувь хэмжээг **Хавсралт 6**-аас үзнэ үү. ХЯТ-ний шатлалаар тооцсон ЕЕН-ийн эмнэлгийн хөнгөлөлтийн хувь хэмжээг **Хавсралт 7**-гоос үзнэүү .
  - iii. 2022 оны 1-р сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон Иллиной муж улсын Эмнэлгийн Даатгалгүй Өвчтөний Хөнгөлөлтийн тухай хуулийн дагуу (210 ILCS 89/1) Иллиной муж улсын оршин суугч ба эмнэлгийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээний төлбөр нь 150 ам.доллаароос давсан дүнтэй өвчтөнүүдээр хязгаарладаг. Мөн уг хуулийн дагуу NS-ЕЕН нь эмнэлгийн өртөг үнийн харьцааны 135%-ийн хөнгөлөлтийг ерөнхийд нь нэхэмжилсэн дүнтэй харьцуулж, өвчтөнүүдэд зориулж илүү сайн хөнгөлөлт олгосон.
  - iv. NS-ЕЕН нь Холбооны Мэргэшсэн эрүүл мэндийн төв (FQHC/ХМЭМТ)/олон нийтийн эрүүл мэндийн төв эсвэл үнэ төлбөргүй, буяны эмнэлгээс үзүүлж буй олон нийтэд түшиглэсэн анхан шатны тусламж үйлчилгээ авсан, NS-ЕЕН-д шилжүүлсэн даатгалгүй өвчтөнүүдэд санал болгож, мөн даатгалгүй өвчтөнийг улсын эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрт хамрагдах боломжтой гэж үзэх үндэслэлтэй бол улсын эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрт хамрагдах өргөдөл гаргахдаа тусламж авахын тулд үзлэгт хамрагдах боломжоор яаралтай тусламжийн бус эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжоор хангана ХМЭМТ/ олон нийтийн эрүүл мэндийн төв эсвэл үнэ төлбөргүй болон буяны эмнэлгээс үзүүлж буй олон нийтэд түшиглэсэн анхан шатны тусламж үйлчилгээ авч, даатгалд хамрагдаагүй өвчтөн хамрагдах боломжтой гэж үзэх үндэслэлгүй эмнэлгийн байгууллагад шилжүүлсэн даатгалгүй өвчтөн. улсын эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрт хамрагдах хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлэх үйлчилгээний хуваарь гарсан тохиолдолд эмнэлгийн санхүүгийн тусламж авах өргөдөл гаргах боломж олгоно.
- D. *Даатгалтай өвчтөний санхүүгийн тусламж авах эрх бүхий байдал:* ХЯТ-д тулгуурлан, санхүүгийн тусламж авах шаардлагад тэнцсэн даатгалтай өвчтөнүүдэд санал болгох хөнгөлөлтийг тодорхойлоход дараах хүснэгтийг ашиглана. Эрүүл мэндийн даатгал нь эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний төлбөрийг төлсний дараа өвчтөнүүд үлдэгдэл төлбөр тооцоондоо (өөрөө төлсөн төлбөрийн үлдэгдэл) санхүүгийн тусламж авах өргөдөл гаргах боломжтой. Даатгалтай өвчтөнүүдийн хувьд санхүүгийн тусламжийг 150 ам.доллар ба түүнээс дээш хэмжээний төлбөрийн үлдэгдэлтэй өвчтөнүүдэд олгоно. Өвчтөнүүдээс НЕД-ээс хэтэрсэн хэмжээгээр төлбөр нэхэмжлэхгүйн тулд НЕД-ийн хувийн хязгаарыг бодолцон санхүүгийн тусламж авах шаардлагыг хангасан өвчтөнүүдэд олгох хөнгөлөлтийг дахин хянаж үзнэ. ХЯТ-ний шатлалаар тооцсон NS-

ЕЕН-ийн хөнгөлөлтийн хувь хэмжээг **Хавсралт 4**-өөс үзнэүү . ХЯТ-ний шатлалаар тооцсон Шведийн эмнэлгийн хөнгөлөлтийн хувь хэмжээг **Хавсралт 5**-аас үзнэ.үү ХЯТ-ний шатлалаар тооцсон NSH-ийн хөнгөлөлтийн хувь хэмжээг **Хавсралт 6**-аас үзнэ үү. ХЯТ-ний шатлалаар тооцсон ЕЕН-ийн эмнэлгийн хөнгөлөлтийн хувь хэмжээг **Хавсралт 7**-гоос үзнэ үү. Доор дурдсан удирдамжид зааснаас давсан өрхийн орлоготой өрхүүдийг төлбөрийн төлөвлөгөөний дагуу шалгаж болно.

ХЯТ-ний шатлал	0% – 200% ХЯТ	201% - 400% ХЯТ
Өвчтөний тооцоолсон төлбөр	\$0 төлбөр/100% хасах	НЕД-ийн хувь хэмжээг үржих нь өөрөө төлсөн төлбөрийн үлдэгдэл

СТЖ-ын **Хавсралт 3**-аас ХЯТ-ний мэдээллийг үзэж болох ба эмнэлэг тус бүрийн НЕД-гийн хувь хэмжээг **Хавсралт 2**-оос үзнэ үү.

- Е. *Үндэслэлтэй эрх бүхий байдал*: Доор дурдсан шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгэнд тулгуурлан даатгалгүй өвчтөнүүдийг санхүүгийн тусламж авах шаардлага хангасан, эрх бүхий хэмээн тодорхойлж болно. Шалгуур үзүүлэлтүүдийн ядаж нэгийг нь батлан харуулсан нөхцөлд орлогын ямар ч нотолгоо шаардагдахгүй. Доор дурдсан жагсаалт бол өвчтөний өрхийн орлого ХЯТ-аас хоёр дахин бага бөгөөд өвчтөн эмнэлгийн шаардлагатай төлбөрөөс 100% чөлөөлөгдөх эрхтэй байх нөхцөл үүссэний нэг жишээ юм. Даатгалгүй өвчтөний хувьд эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээг хүлээн авснаас хойш аль болох хурдан хугацаанд, тэдгээр үйлчилгээний төлбөр тооцоог гаргахаас өмнө үндэслэлтэй эрх бүхий байдлаа шалгуулах болон хянуулах хэрэгтэй. Санхүүгийн тусламж авах эрх бүхий байдлын боломжийн талаар мэдэгдсэн тохиолдолд NS-ЕЕН үндэслэлтэй эрх бүхий байдлын хяналтын үйл явцыг дуусгах явцад өвчтөнд ирүүлэх аливаа мэдэгдлийг ирүүлсээр байна. Мөн түүнчлэн нөхцөл байдлыг шийдвэрлэхдээ хувь хүмүүсийн үндэслэлтэй эрх бүхий байдлыг урьдчилан баталгаажуулахын тулд NS-ЕЕН-ийн зүгээс хөндлөнгийн буяны болон ашгийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж болно. Эдгээр байгууллагын тоонд холбооны хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэшсэн эрүүл мэндийн клиникүүд, шашны болон ашгийн бус байгууллагууд багтана.
- i. Дараах хөтөлбөрүүдийн аль нэгэнд бүртгүүлж хамрагдсанаар Үндэслэлтэй эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлтийг хангана. Үүнд:
    - a) Эмэгтэйчүүд, нялхас, хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөр (WIC/ЭНХХТХ)
    - b) Нэмэлт шим тэжээлийн тусламжийн хөтөлбөр (SNAP/НШТТХ)
    - c) Иллиной муж улсын Үнэгүй өдрийн хоол, өглөөний цайны хөтөлбөр
    - d) Бага орлоготой өрхөд туслах хөтөлбөр (LINEAR/БООТХ)
    - e) Хэрэгцээт өрхүүдэд зориулсан түр тусламжийн хөтөлбөр (TANF/ХӨЗТТХ)
    - f) Иллиной муж улсын орон сууцны хөгжлийн газрын түрээсийн орон сууцаар дэмжих хөтөлбөр
    - g) Зохион байгуулалттай нийгэм -суурьтай хөтөлбөр буюу Бага орлоготой санхүүгийн байдлыг шалгуур үзүүлэлтээр тогтоож эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг буяны эрүүл мэндийн хөтөлбөр
    - h) Medicaid хөтөлбөрт хамрагдах эрхтэй боловч үйлчилгээ үзүүлсэн өдөр эсвэл хөтөлбөрийн хүрээнд багтаагүй үйлчилгээнд хамаарахгүй
  - ii. Үндэслэлтэй эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлтийг амьдралын дараах нөхцөлийг харгалзан баталгаажуулна. Үүнд:
    - a) Эмнэлгийн үйлчилгээний мөнгөн тусламж авсан
    - b) Орон гэргүй
    - c) Өв хөрөнгөгүй талийгаач
    - d) Төлөөлөх хүнгүй сэтгэцийн эмгэгтэй өвчтөн
    - e) Саяхан дампуурсан
    - f) Хорих ангид хоригдсон
    - g) Шашны мяндагтан ба шашны тангарагтай холбоотой
    - h) Өрхийн орлого нь ХЯТ-ээс хоёр дахин бага болохыг нотолсон хараат бус гуравдагч этгээдээс гаргаж өгсөн нотолгоо
  - iii. Үндэслэлтэй эрх бүхий байдлыг дараах аргуудаар батална. Үүнд:
    - a) Хөтөлбөрт хамрагдсан болон бусад төрлийн үндэслэлтэй эрх бүхий байдлын шалгуурыг хангасан тухай цахим баталгаажуулалт

b) Хараат бус цахим баталгаажуулалт гаргах боломжгүй бол хөтөлбөрт хамрагдсан эсвэл бусад эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлтийг хангасан тухай нотолгоог шаардаж болно. Дараах зүйлсийн аль нэгийг хангалттай нотолгоонд тооцно:

1. ЭНХХТХ-ийн эрхийн бичиг
2. НХТТХ-ийн карт, хөтөлбөрт хамрагдсаныг нотлох хэвлэмэл баримт, НХТТХ-т хамрагдахыг зөвшөөрсөн бичиг
3. Сургуулийн тамгатай тодорхойлолт эсвэл Үнэгүй/Хямдарсан хоолны эрхийн бичиг, Төлбөрөөс чөлөөлөх тухай гарын үсэг бүхий мэдэгдэл
4. БОӨТХ-т хамрагдсан тухай мэдэгдэл эсвэл зөвшөөрлийн бичиг
5. Улаан загалмай, ИҮД, Эрүүл мэнд, үйлчилгээний газрын (DHS/ЭМҮГ)-ын ХӨЗТТХ-т хамрагдахыг зөвшөөрсөн бичиг
6. Мужийн эсвэл холбооны татаасаар орон сууцны хөтөлбөрт хамрагдсан бол түрээсийн баримт
7. Түрээслэгчээс өгсөн түрээсийн тохиролцооны бичиг эсвэл Орон сууц, хот байгуулалтын хэлтсийн (HUD/ОСХБХ) карт эсвэл албан бичиг
8. Иллиной муж улсын хөтөлбөрт одоогоор хамрагдах эрхтэй байгааг харуулах карт, мэдэгдэл
9. Тэтгэлгийн байгууллагын тодорхойлолт эсвэл Мөнгөн тусламжийн бичиг
10. Орон гэргүй болохыг нотолсон өөрийн захидал эсвэл сүмийн/орон байраар хангагчийн бичиг
11. Өмгөөлөгч, бүлгээр амьдрагчид, орон байраар хангагч, шашны мяндагтан эсвэл сүмийн албан бичиг
12. Дампуурлын бүртгэлд NS-ЕЕН-ийг зээлдэгчээр тодорхойлсон Өр төлбөрөөс чөлөөлөх тухай мэдэгдэл

F. *Эрх бүхий байдлын хугацаа:* Даатгалгүй өвчтөнүүдийн хувьд санхүүгийн тусламжийн тодорхойлолт өргөдлийн хугацааны турш хамаарах бүхий л төлбөр тооцооны үлдэгдэлд цаг хугацаа харгалзахгүй үйлчлэх бөгөөд цаашид өвчтөн ямар нэгэн арга хэмжээ авахгүй бол хамгийн багадаа зургаан сарын хугацаанд үйлчлэх болно. Зургаан сарын хугацаанд өвчтөний санхүүгийн нөхцөл байдалд санхүүгийн тусламж олгох шийдвэрт нөлөөлж болзошгүй ямар нэгэн өөрчлөлт гарвал өвчтөн энэ талаар уг өөрчлөлт бий болсноос хойш гучин (30) хоногийн дотор NS-ЕЕН-т даруй мэдэгдэнэ. Өрхийн орлогод бодит ахиц гарсан талаар өвчтөн мэдэгдээгүй бол бодит өөрчлөлт гарснаас хойш NS-ЕЕН-ийн зүгээс тухайн өвчтөнд үзүүлсэн аливаа санхүүгийн тусламжийг хүчингүй болгож болзошгүй. Даатгалгүй өвчтөнүүдийн хувьд үндэслэлтэй эрх бүхий байдлын тодорхойлолт нь өвчтөн өөрөө төлөх бүхий л нээлттэй төлбөр тооцооны үлдэгдэлд үйлчилж болно.

G. *Санхүүгийн тусламж авах эрхийг тодорхойлох эцсийн байдал:* Даатгалтай өвчтөнүүд ирээдүйд авах эмнэлгийн яаралтай болон зайлшгүй шаардлагатай үйлчилгээндээ санхүүгийн тусламж авах өргөдлийг дахин гаргаж болно. Энэ тохиолдолд даатгал болон хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодорхойлж, санхүүгийн тусламжийн тодорхойлолт гаргах зорилгоор орлогыг тооцоолохын тулд хөндлөнгийн байгууллагын мэдээлэл/ЕЕН-ийн дансны авлага/төлбөр/буяны үйл ажиллагаа/найдаргүй өр төлбөрийн түүх, Evanston Hospital, Erie Family Health Center зэрэг NS-ЕЕН Нийгэмлэгийн Эрүүл мэндийн төвийн гишүүнчлэлийн мэдээлэл зэргийг ашиглаж болно. NS-ЕЕН зүгээс санхүүгийн нөхцөл байдал нь гуравдагч этгээдийн (зээлийн оноо гэх мэт) баталгаажуулсан өвчтөнүүдийн санхүүгийн тусламж авах өргөдлийг батална. Ийм нөхцөл байдалд санхүүгийн тусламжийн дүнг өвчтөний тооцоонд тусгаж болох бөгөөд өвчтөн санхүүгийн тусламж авах өргөдөл гаргах шаардлагагүй болно. Eхрегiаn төлбөрийн навигацийн систем эсвэл гуравдагч этгээдийн эх үүсвэрийг ашиглах санхүүгийн байдлыг гуравдагч этгээдээр дамжуулан баталгаажуулж болно.

H. *Яаралтай эсвэл эмнэлгийн зайлиггүй шаардлагатай үйлчилгээнүүд:* Санхүүгийн тусламж нь эмнэлгийн байгууламжид үзүүлсэн яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээнүүдээр хязгаарлагддаг. Энэ хэсэгт агуулагдсан ямар ч үг хэллэг өвчтөний төлбөрийн чадварыг үл харгалзан яаралтай эмнэлгийн тусламж, эмчилгээтэй холбогдох холбооны эсвэл мужийн хууль тогтоомжийн дагуу NS-ЕЕН-ийн хүлээсэн үүрэг, тогтсон заншлыг өөрчлөхгүй

I. *Өргөдөл гаргах үйл явц*

- i. *Хэрхэн өргөдөл гаргах вэ:* Санхүүгийн тусламж авах өргөдлийг бүрэн бөглөж, шаардлагатай нэмэлт бичиг баримтуудын хамт өгнө. Өргөдлийн хэвлэх хувилбарыг NS-ЕЕН-ийн [northshore.org/about-us/billing/financial-assistance](http://northshore.org/about-us/billing/financial-assistance) эсвэл [swedishcovenant.org/for-patients-and-visitors/pay-your-bill/financial-assistance](http://swedishcovenant.org/for-patients-and-visitors/pay-your-bill/financial-assistance) эсвэл [nch.org/billing-insurance/financial-assistance](http://nch.org/billing-insurance/financial-assistance) эсвэл [cehealth.org/patients-visitors/manage-my-costs-and-billing/billing/financial-assistance](http://cehealth.org/patients-visitors/manage-my-costs-and-billing/billing/financial-assistance) вебсайтуудаас татаж авч болно. Мөн яаралтай тусламжийн тасаг, эмнэлгийн бүртгэлийн хэсгүүд дээрээс хэвлэмэл хувиудыг үнэ төлбөргүйгээр авах боломжтой. Үнэгүй хэвлэмэл хувиудыг NorthShore (847) 570-5000, Swedish Hospital-оос (773) 989-3841 (847), NCH-ээс (847) 618-4542, ЕЕН-ээс (866) 756-8348 дугаарын утсаар холбогдож, шуудангаар авах боломжтой.



- ii. *Бөглөсөн өргөдлийг хааш нь илгээх вэ:* Өргөдөл гаргагчид доор дурдсан NS-ЕЕН хаягаар бүрэн бөглөсөн өргөдлийн маягт болон нэмэлт бичиг баримтуудыг ирүүлэх эсвэл эмнэлгийн санхүүгийн зөвлөхөд биеэр авчирч өгч болно. Өвчтөнүүд бүртгэлийн төв хэсэгт очиж, санхүүгийн зөвлөхтэй уулзах өргөдөл гаргаж эмнэлгийн санхүүгийн зөвлөхтэй уулзах боломжтой. Өргөдлийн явцын талаар лавлах, өргөдлийг бөглөхөд тусламж хэрэгтэй бол, ирүүлсэн өргөдөл шийдэгдэх төлөвийг шалгахыг хүсвэл танд туслахын тулд эмнэлгийн санхүүгийн зөвлөх эмнэлэг дээр танд бичлэн туслах бөгөөд та NordShore (847) 570-5000, Swedish Hospital (773) 989-3841, NCH (847) 618-4542, ЕЕН (866) 756-8348 дугаарын утсаар холбоо барьж болно.

NorthShore University HealthSystem  
Patient Financial Services  
P.O. Box 1006, Suite 330  
Skokie, IL 60076-9877  
Факс: (847) 982-6957  
эсвэл  
NorthShore Connect-д оруулах

Swedish Hospital  
Financial Services Center  
5145 N. California Ave.  
Chicago, IL 60625  
Факс: (773) 878-6838  
эсвэл  
NorthShore Connect-д оруулах

Northwest Community Hospital  
NCH Financial Counseling  
800 W. Central Rd.  
Arlington Heights, IL 60005  
Факс: 847-618-4549  
эсвэл  
NCH MyChart-д оруулах

Edward-Elmhurst Health  
Financial Assistance Department  
4201 Winfield Rd.  
Warrenville, IL 60555  
Факс: 331-221-2704  
эсвэл  
И-мэйл хаяг [financialassistance@eehealth.org](mailto:financialassistance@eehealth.org)

- iv. Санхүүгийн тусламж авах, үндэслэлтэй эрх бүхий байдлаа тогтоолгох өргөдлийг өргөдөл хүлээн авах хугацаанд дараах хувь хүмүүсийн аль нь ч гаргаж болно: а) өвчтөн эсвэл батлан даагч, б) өвчтөн эсвэл батлан даагчийн төлөөлөгч, в) өвчтөн/өргөдөл гаргагчийн төлөөлсөн NS-ЕЕН-ийн төлөөлөгч.
- v. Энэхүү журмын аль нэг хэсэгт дурдсан зүйлсийг үл харгалзан санхүүгийн тусламж хүсэх үйл явцад өвчтөн хамтран ажиллаж, бүрэн оролцох үүрэгтэй. Үүнд аливаа боломжит гуравдагч этгээдийн эрүүл мэндийн хамрах хүрээний талаар мэдээлэл өгөх, засгийн газрын болон бусад хөтөлбөрөөр санхүүжилт хүсэх болон өвчтөний санхүүгийн тусламжийн бусад төрөлд хамрагдах боломжийг тодорхойлоход шаардагдах бүхий л баримт бичиг, гэрчилгээнүүдийг цаг тухайд нь өгөх (өөрөөр хэлбэл, Medicare, Medicaid, All Kids, FamilyCare, Асаргаа сувилгааны тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын бирж, гуравдагч этгээдийн хариуцлага, Гэмт хэргийн хохирогчдын санхүүжилт гэх мэт) зэрэг үүрэгтэй. Дээр дурдсан үүргээ биелүүлэхгүй байх нь өвчтөний санхүүгийн тусламж хүссэн өргөдлийг хянахад сөргөөр нөлөөлж болзошгүй. NS-ЕЕН-ийн зүгээс зайлшгүй авч үзэхээс өөр аргагүй нөхцөл байдал үүсээгүй тохиолдолд бол NS-ЕЕН-ийн зүгээс хүсэл гаргаснаас хойш гучин (30) хоногийн дотор өвчтөнүүд шаардлагатай мэдээлэл, гэрчилгээ, бичиг баримтуудыг өгөх шаардлагатай. Өвчтөн үндэслэлтэй байдлаар санхүүгийн тусламж авах эрхтэй биш бол санхүүгийн тусламж авах аливаа өргөдөлд өвчтөн (эсвэл батлан даагч/төлөөлөгч) гарын үсэг зурах ёстой.
- vi. Санхүүгийн зөвлөх санхүүгийн тусламж хүсэх үйл явцад өргөдөл гаргагчид тусламж үзүүлнэ. Хэрэв өвчтөн нас барсан, хариуцах тал тодорхойгүй бол NS-ЕЕН-ийн төлөөлөгч өргөдөл гаргаж, боломжит мэдээлэл, бичиг баримтуудыг (өөрөөр хэлбэл, Medicaid илүүдэл орлогын маягт, хөрөнгийн баримт бичиг гэх мэт) ашиглан өргөдлийг бөглөж болно.

J. *Өрхийн орлого:*

- i. Өрхийн орлогоо тогтоохын тулд өвчтөн дараах бичиг баримтуудын аль нэгийг эсвэл өөрт байгаа баримтуудаа ирүүлнэ. Хэрэв өвчтөний гэр бүлд нэгээс олон хүн хөдөлмөр эрхэлдэг бол хүн тус бүрийн дараах бичиг баримтуудыг өгөх ёстой.
  - a) Бүх өргөдөл гаргагч Иллиной муж улсад оршин суудаг гэдгээ нотлох дараах баримтыг бүрдүүлэх ёстой. Үүнд: муж улсаасолгосон хүчинтэй иргэний үнэмлэх, сүүлийн орон сууцны үйлчилгээний төлбөр, түрээсийн гэрээ, тээврийн хэрэгслийн бүртгэлийн карт, сонгогчийн бүртгэлийн карт, засгийн газрын болон бусад байгууллагаас өргөдөл гаргагч руу илгээсэн бусад шуудан эсвэл найдвартай эх сурвалж, нэг хаягт оршин суудаг гэр бүлийн гишүүний мэдүүлэг, оршин суугаа газрын тодорхойлолт, эсвэл орон гэргүй хүмүүсийг хамгаалах байр, түр байр, бусад адил төстэй байрны тодорхойлох захидал.
  - b) Хэрэв хөдөлмөр эрхэлдэг бол:
    1. Хамгийн сүүлийн холбооны орлогын татварын буцаалт/W-2 маягт, 1099 гэх мэт.
    2. Сүүлийн хоёр сарын цалингийн баримт
    3. Бүх чек, хадгаламж, хамтын зээлийн дансны хамгийн сүүлийн хоёр хуулга
  - c) Хэрэв хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол:
    1. Хамгийн сүүлийн холбооны орлогын татварын буцаалт/W-2 маягт, 1099 гэх мэт.
    2. Бүх чек, хадгаламж, хамтын зээлийн дансны хамгийн сүүлийн хоёр хуулга
  - d) Хэрэв хөдөлмөр эрхэлдэггүй бол:
    1. Хамгийн сүүлийн холбооны орлогын татварын буцаалт/W-2 маягт, 1099 гэх мэт.
    2. Таны олговрын дүнг багтаасан таны ажилгүйдлийн тэтгэмжийн бичиг
    3. Ажлаас гарсан өдрийг дурдсан өмнөх ажил олгогчийн албан бичиг
    4. Дэмжих бичгийн баталгаажуулалт
  - e) Хэрэв үндсэн оюутан бол:
    1. Коллежид элсэн орсныг нотлох баримт (таны үндсэн оюутны статусыг нотлох коллежийн эсвэл их сургуулийн тодорхойлолт, сургалтын төлбөр/санхүүгийн бичиг баримт)
  - f) Хэрэв тэтгэвэрт гарсан эсвэл хөгжлийн бэрхшээлтэй бол:
    1. Хамгийн сүүлийн холбооны орлогын татварын буцаалт/W-2 маягт, 1099 гэх мэт (хэрэв байгаа бол)
    2. Нийгмийн даатгалын газраас ирүүлсэн сарын тэтгэмжийн дүнг дурдсан бичиг
    3. Бүх чек, хадгаламж, хамтын зээлийн дансны хамгийн сүүлийн хоёр хуулга
  - g) Бусад цалингийн бус орлогын нотолгоо (байгаа бол)
    1. Гэр бүлийн хүний/хүүхдийн дэмжих бичиг
    2. Түрээсийн хөрөнгийн орлого
    3. Хөрөнгө оруулалтын орлого
    4. Дээр дурдаагүй бусад орлогын эх үүсвэр
- ii. Үндэслэлтэй эрх бүхий байдлаас бусад тохиолдолд өргөдөл гаргагч нь өргөдлийн баталгаажуулалтад гарын үсэг зурах ёстой. Хэрэв өргөдөл гаргагч хуурамч мэдээлэл өгсөн нь дараа баримтаар нотлогдвол NS-EEN гаргасан шийдвэрээ хүчингүй болгож эсвэл өөрчилж болно.

K. *Нэмэлт бичиг баримт:* Өргөдөл гаргагч нь хөрөнгө, зардал, орлого, төлөгдөөгүй өр төлбөр болон энэхүү СТЖ-ын дагуу авах боломжтой дүнтэй тэнцүү буюу эсвэл түүнээс дээш хэмжээгээр санхүүгийн тусламж хүсэхэд нь дэмжлэг үзүүлэх санхүүгийн хүндрэлтэй байдлыг харуулах бусад нөхцөл байдалтай холбоотой нэмэлт бичиг баримтуудыг өгч болно. Өргөдөл гаргагч нь чек, хадгаламж, тэтгэврийн бус хөрөнгө оруулалтын данс зэрэг зарим хөрөнгийн баримт бичгийг бүрдүүлэх шаардлагатай. Өргөдөл гаргагчийн санхүүгийн байдлыг энэ төрлийн баримт бичигт хангалттай тусгаагүй бол NS-EEN нь өргөдөл гаргагчдаас нэмэлт бичиг баримт бүрдүүлэхийг хүсэж болно.

L. *Эрх бүхий байдлын мэдэгдэл:* NS-EEN нь бүрэн бөглөсөн санхүүгийн тусламж авах өргөдлийг хүлээн авснаас хойш дөчин таван (45) хоногийн дараа санхүүгийн тусламж авах өргөдлийн шийдвэрийг өргөдөл гаргагчдад мэдэгдэхийн тулд боломжтой бүхнийг хийнэ. Энэхүү мэдэгдэлд санхүүгийн тусламжийн хувь хэмжээ (зөвшөөрөгдсөн өргөдлийн хувьд) болон өвчтөн/түүний гэр бүлээс төлөх төлбөрийн дүн зэргийг тусгана. Бөглөсөн өргөдлийг үнэлэх явцад өвчтөн болон түүний гэр бүл өвчтөнд илгээх мэдэгдлийг үргэлжлүүлэн хүлээж авна. Хэрэв санхүүгийн тусламж авах өргөдлийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн тагталзвал ийм шийдвэр гаргасан шалтгаанаа NS-EEN өргөдөл гаргагчид мэдэгдэх бөгөөд хэрэв өргөдөл гаргагчид тодруулах зүйл байвал асууж лавлаж холбоо барих мэдээллийг мөн өгнө.

M. *Бүрэн бус өргөдөл:* Хэрэв өвчтөн/түүний гэр бүл бүрэн бус өргөдөл гаргавал NS-EEN ямар нэмэлт бичиг баримт, мэдээлэл шаардлагатайг тайлбарласан мэдэгдлийг бичгээр гаргаж өгнө.

N. *Худал, ташаа мэдээлэл*: Хэрэв өргөдөл гаргагч эмнэлгийн зардлыг төлөх өөрийн төлбөрийн чадвартай холбогдуулан санаатайгаар худал ташаа мэдээлэл өгсөн нь тогтоогдвол NS-ЕЕН тухайн өргөдөл гаргагчийн одоо гаргасан болон ирээдүйд гаргаж болох өргөдлөөс татгалзана. Санамсар болгоомжгүйгээр худал мэдээлэл өгсөн тохиолдолд NS-ЕЕН өргөдлийг шийдвэрлэхдээ залруулж өгсөн шинэ мэдээлэлд үндэслэнэ. Хэрэв өвчтөний худал, ташаа мэдээлэлд үндэслэн аль хэдийн санхүүгийн тусламж өгсөн бол NS-ЕЕН санхүүгийн тусламж олгосноо хүчингүй болгох бөгөөд энэ тохиолдолд NS-ЕЕН өвчтөний төлөх ёстой бүх төлбөрийг нэхэмжлэн төлүүлэх хууль ёсны эрхээ хадгална. Хэрэв санаандгүй байдлаар худал, ташаа мэдээлэл өгсөн бол NS-ЕЕН залруулсан мэдээлэлд тулгуурлан шийдвэрээ өөрчлөх болно.

## 5. ХАВСРАЛТУУД:

Хавсралт 1 - СТЖ-ын үйлчилгээ үзүүлэгч/эмч нарын жагсаалт  
Хавсралт 2 - Нэхэмжилсэн Ерөнхий Дүнгийн (НED) хувь хэмжээ  
Хавсралт 3 - Холбооны Ядуурлын Түвшин (ХЯТ)-гийн удирдамж  
Хавсралт 4 - NorthShore Санхүүгийн Тусламжийн хөнгөлөлтийн хүснэгт  
Хавсралт 5 - Swedish Hospital Санхүүгийн тусламжийн хөнгөлөлтийн хүснэгт  
Хавсралт 6 - NCH Hospital Санхүүгийн тусламжийн хөнгөлөлтийн хүснэгт  
Хавсралт 7 - Edward-Elmhurst Эрүүл мэндийн санхүүгийн тусламжийн хөнгөлөлтийн хүснэгт

## 6. АНГИЛАЛ:

Захиргааны удирдамжийн гарын авлага

## 7. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАРИУЦАХ ЭТГЭЭД:

Тэргүүн дэд ерөнхийлөгч, Бизнесийн алба

## 8. ИШ ТАТСАН ЗҮЙЛС:

<u>Дотоод</u>	<u>Гадаад</u>
Захиргааны удирдамжийн гарын авлага: Нэхэмжлэх ба төлбөр барагдуулалтын журам	Эрүүл мэнд, иргэдийн үйлчилгээ (ННС/ЭМИУ)
Захиргааны удирдамжийн гарын авлага: Эмнэлгийн яаралтай эмчилгээ ба хөдөлмөрийн хуулийн (НРАА/ЭМДШХТХ) хэрэгжүүлэх журам: (Менежментийн менежмент)	Хамгийн сүүлийн оны Холбооны ядуурлын судалгаа тайлан
Захиргааны удирдамжийн гарын авлага: ЭМДШХТХ хэрэгжүүлэх журам	Эмнэлгийн даатгалгүй өвчтөний хөнгөлөлтийн тухай хууль (210 ILCS 89/1)
ЭЯТЭХХ-ийг дагаж мөрдөх журам: ЭЯТЭХХ-ийн Эрүүл мэндийн үзлэгийн журам	Дотоод орлогын код 501(r) хэсэг

## 9. ШИНЭЧЛЭХ:

Байгууллага нь хуулийн хязгаарлалтын хүрээнд үндэслэлтэй мэдэгдэл хүргүүлэн эсвэл эс хүргүүлэн энэхүү журмын нөхцөлүүдийг дангаараа хянан засварлах, өөрчлөх, хянах, өөрчлөх эрхтэй.

## 10. БАТАЛСАН:

\_\_\_\_\_ Грег Арнольд (Greg Arnold) \_\_\_\_\_ Тэргүүн дэд ерөнхийлөгч, Бизнесийн алба \_\_\_\_\_ 2023/1/6  
Гарын үсэг Албан тушаал Огноо

## 11. ОГНОО:

Гарал үүсэл: 6/2004 Хяналт: 2023/6 Хүчин төгөлдөр: 2023/6 Дараагийн хяналт: 2026/6

### Хавсралт 1 СТЖ-ын үйлчилгээ үзүүлэгч/эмч нарын жагсаалт

NorthShore, Swedish, NCH, EEN Medical Group-ын бүх эмч/үйлчилгээ үзүүлэгчид энэ журамд хамрагдана. Энэхүү журамд хамрагдаагүй NS-EEN эмнэлгийн байгууламжуудад яаралтай эмнэлгийн байгууллага бүрт яаралтай болон бусад шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлдэг бие даасан/ажил эрхлээгүй үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалтыг тус тусын эмнэлгүүдийн доорх вебсайтын хаягаар онлайнаар тусдаа баримт бичигт байршуулсан. Эдгээр жагсаалтын хэвлэмэл хувийг тус өргөдлийн дагуу яаралтай тусламжийн тасаг, эмнэлгийн бүртгэлийн хэсэгт, тус тусын эмнэлэг тус бүрийн доор жагсаасан утасны дугаараар шуудангаар авах боломжтой. Үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалтыг улирал тутамд шинэчилнэ.

Эмнэлэг	Вебсайт дээрх байршил	Утасны дугаар
Evanston Hospital Glenbrook Hospital Skokie Hospital Highland Park Hospital	<a href="http://northshore.org/about-us/billing/financial-assistance">northshore.org/about-us/billing/financial-assistance</a>	(847) 570-5000
Swedish Hospital	<a href="http://swedishcovenant.org/for-patients-and-visitors/pay-your-bill/financial-assistance">swedishcovenant.org/for-patients-and-visitors/pay-your-bill/financial-assistance</a>	(773) 989-3841
Northwest Community Hospital	<a href="http://nch.org/billing-insurance/financial-assistance">nch.org/billing-insurance/financial-assistance</a>	(847) 618-4542
Edward Hospital Elmhurst Hospital Linden Oaks Hospital	<a href="http://eehealth.org/patients-visitors/manage-my-costs-and-billing/billing/financial-assistance">eehealth.org/patients-visitors/manage-my-costs-and-billing/billing/financial-assistance</a>	(866) 756-8348

## Хавсралт 2 Нэхэмжилсэн ерөнхий дүн (Amounts Generally Billed) (НED)

Санхүүгийн тусламж авах шаардлага хангасан өвчтөнүүдээс яаралтай тусламжийн болон эмнэлгийн зайлшгүй тусламжийн үйлчилгээний төлбөрийг даатгалтай өвчтөнүүдийн нэхэмжилсэн ерөнхий дүнгээс (НED) хэтэрсэн дүнгээр нэхэмжлэхгүй. Эмнэлгийн НED-ийн хувь хэмжээг 12 сарын хугацаанд эдгээр нэхэмжлэлд ногдуулсан нийт дүнд хуваагдсан “Медикэйр” (Medicare) үйлчилгээний хураамж болон хувийн эрүүл мэндийн даатгуулагчийн нэхэмжлэлийн нийт дүн болох “дахин хянах” аргыг ашиглан тооцно. Өвчтөнүүдээс НED-ээс хэтэрсэн хэмжээгээр төлбөр нэхэмжлэхгүйн тулд НED-ийн хувийн хязгаарыг бодолцон санхүүгийн тусламж авах шаардлагыг хангасан өвчтөнүүдэд олгох хөнгөлөлтийг дахин хянаж үзнэ.

Үйлчилгээ үзүүлэгч	НED %	Хөнгөлөлт %
Evanston Hospital and Medical Group	29%	71%
Glenbrook Hospital and Medical Group	29%	71%
Highland Park Hospital and Medical Group	29%	71%
Skokie Hospital and Medical Group	29%	71%
Swedish Hospital and Medical Group	22%	78%
Northwest Community Hospital and Medical Group	28%	72%
Edward Hospital and Medical Group	18%	82%
Elmhurst Hospital and Medical Group	17%	83%
Linden Oaks Hospital and Medical Group	43%	57%

Энэ журмыг хэрэгжүүлэх НED-ийн хувь хэмжээг жил бүр шинэчлэн тооцдог бөгөөд он гарснаас хойш 120 дахь өдрийн дараа мөрдөж эхэлнэ.

### Хавсралт 3 Холбооны Ядуурлын Түвшин (ХЯТ)-гийн удирдамж

Энэхүү журамд дурдсан ядуурлын түвшний удирдамжийг АНУ-ын Эрүүл мэнд, Иргэдэд үйлчлэх газраас жил бүр шинэчлэн гаргадаг бөгөөд Холбооны бүртгэлд оруулж нийтлүүлдэг. Одоогийн байдлаар ашиглагдаж буй ядуурлын түвшингийн удирдамжийн орлогын босго хэмжээг 2025 оны 1 сарын 16-ны өдөр нийтэлсэн.

Ам бүлийн тоо	ХЯТ
1	\$15,650
2	\$21,150
3	\$26,650
4	\$32,150
5	\$37,650
6	\$43,150
7	\$48,650
8	\$54,150

*Ам бүлийн тоо нь 8-аас дээш байх өрхийн нэгжсийн хувьд ХЯТ-ийг тодорхойлохын тулд нэмэгдсэн хүн тус бүрд 5,500 ам.доллар нэм.*

Хэдийгээр зарим заалтаар эмчилгээний онцгой зардлуудын орлогод тохируулга буюу тохируулах бичилт хийхийг зөвшөөрдөг боловч энэ журмын зорилгын улмаас дээр дурдсан орлогын түвшнийг нийт орлого гэж ойлгоно Энэхүү журамд ашиглахын тулд холбооны ядуурлын түвшнийг холбооны засгийн газраас хянан баталгаажуулж, Холбооны Бүртгэлд бүртгэж, нийтэлсний дараа жил бүр шинэчлэн гаргадаг.

**Хавсралт 4**  
**NorthShore Санхүүгийн Тусламжийн хөнгөлөлтийн хүснэгт**

**ДААТГАЛГҮЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалгүй өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-600% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	71% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$93,900
2	\$42,300	\$126,900
3	\$53,300	\$159,900
4	\$64,300	\$192,900
5	\$75,300	\$225,900
6	\$86,300	\$258,900
7	\$97,300	\$291,900
8	\$108,300	\$324,900
Жилийн хамгийн их төлбөр	\$0 төлбөр/100% хөнгөлөлт	Өрхийн жилийн орлогын 20%

**ДААТГАЛТАЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалтай өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний өвчтөн өөрөө төлөх төлбөрийн үлдэгдэлд энэхүү хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-400% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	71% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$62,600
2	\$42,300	\$84,600
3	\$53,300	\$106,600
4	\$64,300	\$128,600
5	\$75,300	\$150,600
6	\$86,300	\$172,600
7	\$97,300	\$194,600
8	\$108,300	\$216,600

**Хавсралт 5**  
**Swedish Hospital санхүүгийн тусламжийн хөнгөлөлтийн хүснэгт**

**ДААТГАЛГҮЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалгүй өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-600% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	78% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$93,900
2	\$42,300	\$126,900
3	\$53,300	\$159,900
4	\$64,300	\$192,900
5	\$75,300	\$225,900
6	\$86,300	\$258,900
7	\$97,300	\$291,900
8	\$108,300	\$324,900
Жилийн хамгийн их төлбөр	\$0 төлбөр/100% хөнгөлөлт	Өрхийн жилийн орлогын 20%

**ДААТГАЛТАЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалтай өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний өвчтөн өөрөө төлөх төлбөрийн үлдэгдэлд энэхүү хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-400% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	78% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$62,600
2	\$42,300	\$84,600
3	\$53,300	\$106,600
4	\$64,300	\$128,600
5	\$75,300	\$150,600
6	\$86,300	\$172,600
7	\$97,300	\$194,600
8	\$108,300	\$216,600



**Хавсралт 6**  
**NCH санхүүгийн тусламжийн хөнгөлөлтийн хүснэгт**

**ДААТГАЛГҮЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалгүй өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-600% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	72% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$93,900
2	\$42,300	\$126,900
3	\$53,300	\$159,900
4	\$64,300	\$192,900
5	\$75,300	\$225,900
6	\$86,300	\$258,900
7	\$97,300	\$291,900
8	\$108,300	\$324,900
Жилийн хамгийн их төлбөр	\$0 төлбөр/100% хөнгөлөлт	Өрхийн жилийн орлогын 20%

**ДААТГАЛТАЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалтай өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний өвчтөн өөрөө төлөх төлбөрийн үлдэгдэлд энэхүү хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-400% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	72% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$62,600
2	\$42,300	\$84,600
3	\$53,300	\$106,600
4	\$64,300	\$128,600
5	\$75,300	\$150,600
6	\$86,300	\$172,600
7	\$97,300	\$194,600
8	\$108,300	\$216,600

**Хавсралт 7****Edward Hospital санхүүгийн тусламжийн хөнгөлөлтийн хүснэгт****ДААТГАЛГҮЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалгүй өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-600%ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	82% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$93,900
2	\$42,300	\$126,900
3	\$53,300	\$159,900
4	\$64,300	\$192,900
5	\$75,300	\$225,900
6	\$86,300	\$258,900
7	\$97,300	\$291,900
8	\$108,300	\$324,900
Жилийн хамгийн их төлбөр	\$0 төлбөр/100% хөнгөлөлт	Өрхийн жилийн орлогын 20%

**ДААТГАЛТАЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалтай өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний өвчтөн өөрөө төлөх төлбөрийн үлдэгдэлд энэхүү хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-400% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	82% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$62,600
2	\$42,300	\$84,600
3	\$53,300	\$106,600
4	\$64,300	\$128,600
5	\$75,300	\$150,600
6	\$86,300	\$172,600
7	\$97,300	\$194,600
8	\$108,300	\$216,600

**Хавсралт 7**  
**Elmhurst Hospital санхүүгийн тусламжийн хөнгөлөлтийн хүснэгт**

**ДААТГАЛГҮЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалгүй өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-600% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	83% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$93,900
2	\$42,300	\$126,900
3	\$53,300	\$159,900
4	\$64,300	\$192,900
5	\$75,300	\$225,900
6	\$86,300	\$258,900
7	\$97,300	\$291,900
8	\$108,300	\$324,900
Жилийн хамгийн их төлбөр	\$0 төлбөр/100% хөнгөлөлт	Өрхийн жилийн орлогын 20%

**ДААТГАЛТАЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалтай өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний өвчтөн өөрөө төлөх төлбөрийн үлдэгдэлд энэхүү хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-400% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	83% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$62,600
2	\$42,300	\$84,600
3	\$53,300	\$106,600
4	\$64,300	\$128,600
5	\$75,300	\$150,600
6	\$86,300	\$172,600
7	\$97,300	\$194,600
8	\$108,300	\$216,600

**Хавсралт 7****Linden Oaks Hospital санхүүгийн тусламжийн хөнгөлөлтийн хүснэгт****ДААТГАЛГҮЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалгүй өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-600% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	57% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$93,900
2	\$42,300	\$126,900
3	\$53,300	\$159,900
4	\$64,300	\$192,900
5	\$75,300	\$225,900
6	\$86,300	\$258,900
7	\$97,300	\$291,900
8	\$108,300	\$324,900
Жилийн хамгийн их төлбөр	\$0 төлбөр/100% хөнгөлөлт	Өрхийн жилийн орлогын 20%

**ДААТГАЛТАЙ ӨВЧТӨНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХҮСНЭГТ**

ХЯТ шатлалаар гаргасан даатгалтай өвчтөнүүдийн хөнгөлөлтийн хувь хэмжээг доор үзүүлэв. Яаралтай эсвэл эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний өвчтөн өөрөө төлөх төлбөрийн үлдэгдэлд энэхүү хөнгөлөлтийн хувь хэмжээг тооцно.

Ам бүлийн тоо	0%-200% ХЯТ	201%-400% ХЯТ
	100% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ	57% хөнгөлөлт эдлэх орлогын хамгийн их хэмжээ
1	\$31,300	\$62,600
2	\$42,300	\$84,600
3	\$53,300	\$106,600
4	\$64,300	\$128,600
5	\$75,300	\$150,600
6	\$86,300	\$172,600
7	\$97,300	\$194,600
8	\$108,300	\$216,600